

Манжийн алигали үсгийн тухайд

М.Баярсайхан (МУИС)

1. Манж үсэг галиг үсгийн үүрэг гүйцэтгэж байсан нь

Манж үсэг бичгийн нэг онцлог нь манж төдийгүй бусад олон хэлний үгийг нарийвчлан тэмдэглэх бололцоотой буюу авианы галиг үсгийн үүргийг гүйцэтгэж чаддаг явдал юм. "Манж хэл бичиг нь нэгэн үе Алс Дорно зүгийн латин гэж Европод нэрлүүлж байсан" тухай Б.Ринчен багштаны тэмдэглэсэн зүйл чухам энэ онцлогтой холбоотой биз ээ. (6-19, 7-51-р тал). Манж бичиг нь зөв бичих зүйн хувьд нарийн боловсорч чадаагүй хэмээн¹ зарим судлаач бичсэн нь арай ч халгуурсан үг агаад харин ч манж бичгийн хэлний зөв бичихзүй уул хэлнийхээ зүй тогтлыг тун зөрчил багатай тусгаж чадсан гэж үзэх нь зүйтэй.

"Хааны бичсэн манж үгийн толь бичиг" (1717), "Хааны бичсэн манж монгол хятад үгийн гурван зүйлийн аялгуу нийлсэн толь бичиг" (1771), "Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсэг хавсарсан толь бичиг" (1779 оны орчим) "Хааны бичсэн таван зүйлийн үсэг хавсарсан манж үгийн толь бичиг" (1790 оны орчим) зэрэгт ээлж дараалан монгол, хятад, төвд, уйгур үгийн дуудлагыг манж үсгээр хадсан байдаг нь тэдгээр хэлний тухай тухайн цаг үеийн зөв дуудах зүйг судлах чухал хэрэглэгдэхүүн болно. Зах зухаас нь ганц нэг жишээ дурдваас, монгол үгийн дуудлагыг хадсан зүйлд *olan-u* гэдгийг *olan-nu* гэх мэтээр "n" гийгүүлэгчээр төгссөн үгийн дараахи харьяалахын тийн ялгалыг "nu, nü"-ээр дуудахаар тэмдэглэжээ. Энэ нь "МНТ"-ны хятад галигт тэмдэглэгдэж байсан тэрхүү гийгүүлэгчийг давхар дуудах ёс 18-р зууны үед тод байсныг нотолж байна. Түүхэн сурвалжид буй зарим монгол хүний нэр, газар усны нэрийг кирилл үсэгт тааварлан буулгасаар буйг чухам манж бичгээс л лавлалтай билээ. Тухайлбал, анх манжид дагаар орсон нэгэн ноёны нэрийг манайхан Энхдар хэмээн буулгаад байгаа нь манж сурвалж бичигт Энгэдэр хэмээн дуудлага тодорхой байдаг. Энэ мэт тодлууштай нэр олон буй.

Монгол төрөл хэлтэн болох дагуурчууд 200-гаад жилийн турш өөрийн хэлийг манж үсгээр авиачлан тэмдэглэж байсан нь эл хэлийг судлахад онц ач холбогдолтой нэлээд баримт буй болгожээ.

Түүнчлэн "Musei ejen Isus Heristos-i tutabuha iče hese" хэмээх 1835 онд хэвлэгдсэн манж хэлээрхи Библийн судрыг үзвэл, европ зүгийн хэлний үгийг манж үсгээр тэмдэглэх бүрэн боломжтой нь тодорхой харагдаж байна.

Манж хэл нь үгийн сан, хэлзүйн байгууламжийн хувьд монгол хэлтэй олон зүйлээр нийтлэг байдаг, нөгөөтэйгүүр манж үсгийг монгол үсэгт суурилан боловсруулсан тул монголчууд манж хэл бичгийг сурч эзэмшихэд тун дөхөмтэй байдаг билээ. Иймээс ялангуяа 19-р зууны үе,

¹ Боловсорч чадаагүй баримт болгож үзээд буй зарим нөхцөлийн бичлэгийн тухайд өөр ямар аргаар шийдэж болох байсан эсэх тухайд хэлшинжлэлчийн үүднээс тунгаан шүүгээд дэлгэрэнгүй тайлбарлан бичиж байж ийм дүгнэлт хийх ёстой.

20-р зууны эхээр монгол хүн манж бичгийн дуудлага ялгах тэмдгийг монголоор бичсэн зүйдээ хэрэглэсэн нь олонтаа байсан.

Манжаар дамжуулан монголчилсон эртний хятадын сонгодог зохиолууд, Эрдэнийн эрх зэрэг түүхийн сурвалж, архив албан бичгийн зүйлд харь хэлний оноосон нэрийг манж үсгээр тодлон бичсэн зүйл нэлээд байхаас гадна зарим бичгийн дотор ерийн түгээмэл хэрэглээний монгол үсгийг хүртэл манжаар бичсэн нь тохиолддог.

Монголчууд Аюуш гүүшийн галигийн зэрэгцээ Чингийн үеийн төрийн бичиг байсан манж үсгийг үсэг бүр нь нэг авиаг тэмдэглэдгийн хувьд мөн галигийн үүргээр хэрэглэж байсан бөгөөд монголын шашны номын хэлтэн ба төрийн номын хэлтэн нь өөр өөрийн бичгийн боловсролдоо ойр дөтийг нь хэрэглэн заншиж байжээ. Шашны утга зохиолын зүйлд ч хүртэл төвд үгийн дуудлагыг манж үсгээр галиглан бичиж байв. Үүний нэгэн баримт болох манж үсгээр дуудлага тэмдэглэсэн "Арван гурван сангийн судар"-ыг тус өгүүллийн хойно хавсаргав.

2. Манжийн "гадаад үсэг" түлэргү хэргэн

Дахай багш дусал бинтэт манж үсгийг боловсруулахын хамт хятад үсгийг тэмдэглэх зорилгоор "гадаад үсэг" буюу манжаар "түлэргү хэргэн" хэмээх галиг үсгийг зохиожээ. Манжийн ноёрхогчид эзэлсэн ард түмэн, түүний дотор давын өмнө хүн ам ихтэй хань үндэстнийг захиран эрхшээхийн тулд хятад үндэстний хэл соёлыг сурч судлах, наад зах нь хятад газар усны нэр, хүний нэр зэргийг манж үсгээрээ зөв буулган тэмдэглэх шаардлага тулгамджээ.

1630-аад оны үеэс манж нар хятадын сонгодог зохиолоос орчуулж эхэлсэн бөгөөд Дахай багш "Мэнз бичиг", "Гурван улсын үлгэр" зэргийг анх манжаар орчуулахдаа хятад үгийг тэмдэглэх үсгийн хэрэгцээ шаардлагыг биеэр мэдэрч байсан нь дамжиггүй. Үүний урьд дусал бинтгүй үсгийн бичгийн үед манж нар хятад үгийг бичих тогтолцоогүй бөгөөд хятадын ойр төрлийн авиаг ялгалгүй нэг дүрсээр бичиж байв.

Тэр бээр Монголчуудын хятад үгийг бичиж тэмдэглэж ирсэн уламжлалыг мэдэж байсан бололтой авч монгол галиг үсгээс зөвхөн ᠪ үсгийг авч дусал бинт нэмэн ᠪ ᠪ ᠪ гурван үсгийг бий болгожээ.

Аюуш гүүш төвд, самгарди үсэгт тохируулан ᠨ ᠨ ᠨ үсгийг зохиосон бол Дахай багш хятадын хэлний сийгэх, исгэрэх, исгэрч сийгэх авиаг тэмдэглэхдээ авианы бүтэх аргын ойр төсөөр нь ᠨ үсгийн махбод дээр нэмэлт тэмдэг оруулж ᠨ ᠨ ᠨ ᠨ ᠨ үсгүүдийг зохиожээ. Эдгээр нь нангиадын үгийг авиачлан тэмдэглэхэд их л нийцтэй дөхөм үсэг болсон бөгөөд тэр цаг үед нь улируулан үзвээс Дахай багш сайн нангиадач, хэлшинжлэлтэн байсныг дурдууштай. Манж ба монгол бичигт хятад, төвд, самгарди болон европ зүгийн хэлийг тэмдэглэхэд тэдгээр ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ нь харилцан дүйж хэрэглэгдэх болжээ.

Мөн ᠨ - ᠨ -ийн ард бинт тавин ялгаж хятад хэлний ci, ji үеийг тэмдэглэсэн ᠨ - ᠨ үсгийг зохиосон бол ᠨ -ийн шилбийг ташуу бус, хөндлөн, нуруунаас хойш гарахаар болгон хувиргаж (ž) үсгийг зохиосон нь монгол галигийн төвд үсгийг дууриалган зохиосон ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ, ᠨ - ᠨ -тэй тус тус дүйнэ.

Мөн манж нар задгай үе болон y, r, n, ng, g, s, d, b, l, w, m гэсэн 11 дэвсгэр үсгээр хаах битүү үеийг тус тус бөлөглөн 12 толгой үсэг хэмээх цагаан толгой зохиосны дотор хятад үгийг тэмдэглэх io, eo, ao, iui, iya, iyo мэтийн хос эгшиг бүхий үеийг оруулсан байдаг.² Энэ бүхэн хожмын манж алигали үсэгт уламжлагдсан юм. Дашрамд өгүүлэхэд, хятад үгийг тэмдэглэх манж,

² Арван хоёр толгой үсэг нь монгол ба хятад хоёр хэлний уламжлалт хэлзүйн нөлөөг аль алиныг тусгасан бөгөөд манж, монгол, хятад гурван хэлний үгийг тэмдэглэхэд хэрэгцээт бүх үсгийг багтаасан байдаг. Жинхэнэ манж үгэнд тохиолдохгүй үе байдаг нь нэг талаар хятад ба монголоос ормол идэвхтэй хэрэглээний үгс цөөнгүй, нөгөө талаар албан бичиг, орчуулга зэрэгт зайлшгүй тохиолдох оноосон нэрийг бичих хэрэгцээг ч бодолцсон хэрэг буй за.

монгол, европын галигийг харилцан харгуулан үзвэл сонирхолтой дүгнэлт гарах бизээ. Миний бодлоор, манж нар нангиад үгийг тэмдэглэх талаар ахархан хугацаанд олон зуун жилийн бичгийн соёлтой монголчуудаас дутахгүй хэмжээнд хүрч чадсан бөгөөд үүнд нь монгол бичгийн туршлага зохих нөлөө үзүүлжээ.

3. Манжийн алигали үсэг зохиогдох болсон шалтгаан, цаг үеийн тухайд

1644 онд Эеэр засагч (*Shunzhi*) хаан ширээнд сууж Бээжинд нийсэллэх болсноос 9 жилийн дараа Далай ламыг залж, бурханы шашныг дэмжин тэтгэх явдлыг манжийн төрийн бодлого болгон явуулж эхэлсэн түүхтэй. Дашрамд дурдахад, энэ хаан чанд нууцлан хаан ороо орхиж сахил хүртэн насан эцэслэлтээ аглаг нэгэн хийдэд даяанчлан суусан гэгддэг билээ.

Дараачийн Энх-Амгалан, Найралт төв зэрэг хаан бурханы шашныг ивээн тэтгэх замаар улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх явдлыг улам бүр идэвхжүүлсэн бөгөөд "Энх-Амгалан хаанаас эхлэн Манжийн хаадыг Манзуширийн хувилгаан хэмээн өргөмжлөх болсон" (14-98т) байна. Гэвч бурханы шашны номыг манжаар орчуулж хэвлүүлэх, төвд хэлний толь зохиох зэрэг ажил одоогийн мэдэгдэж буйгаар Тэнгэрийн тэтгэсэн хааны үеэс эхэлж байна.

Үүнд,

Han-i araha manju niqan tangyud hergen-i qamciha amba yanjur nomun-i uheri tarni (Хааны бичсэн манж хятад төвд үсгээр хавсарсан бүхэл Ганжуурын тарни) (1748 он); *Han-i araha manju, niqan, mongyo, tangyud hergen-i qamciha amba yanjur-i uheri tarni* (хааны бичсэн манж, хятад, монгол, төвд үсгээр хавсарсан бүхэл Ганжуурын тарни (1759 он), *Han-i araha manju mongyo tangyud hergen-i qamciha tarni hulara arya* (Хааны бичсэн манж монгол төвд үсгээр хавсарсан тарни дуудах арга), *Han-i arafa manju niqan mongyo tangyud hergen-i qamciha ali yali* (хааны бичсэн манж, хятад, монгол, төвд үсгээр хавсарсан алигали), *Enduringge waciir-i lashalara sure-i cangi dalin-de aqunaha gebungge amba kulge-i nomun* (Хутагт Очироор огтлогч билгийн чанад хязгаараа хүрсэн нэрт их хөлгөн судар), *Fuchihi-i nomulaha abida nomun* (Бурханы номлосон Авид судар), *Ayduu yabungya sere gebungge nomun toxotoho* (*Suramgamasamadhisutra*), *Sanyan sarangya wesihun mutebuhe gebungge nomun toxotoho* (Цагаан шүхэрт) гэх мэт бас бус нэлээд зохиол Тэнгэрийн тэтгэсний үед гарсан байна.

Төвдөөс орчуулсан хамгийн том зохиол бол манж Ганжуур бөгөөд Рагу Вирагийн бичсэнээр тэрхүү орчуулгын эх нь төвд эх байсан гэжээ. Сураг сонсвол Бээжингийн хааны номын сан болон Лхасад манж Ганжуурын 90 орчим боть байдаг бололтой. Манж алигали үсгийг зохиох болсон гол хэрэгцээ нь эдгээр орчуулгатай шууд холбогдоно.

Нөгөөтэйгүүр, 1708 оны манж үгийн толь бичигт монгол үг хадах ажлыг 1710 оноос эхлэн 1717 онд дуусгаснаас хойш монгол ба хятад хэлний манж орчуулгын толь хэдэнтээ гарч нэлээд зүгширсэн атал төвд хэлний манж толь хараахан гараагүй байсаар сая дөрөв ба таван хэлний толь зохиох цаг үед хүрчээ. Урьдын толиудад манж хүнд зориулан монгол, хятад үгийн дуудлагыг нэгэнт манж үсгээр хадсан байсан бөгөөд таван хэлний тольд төвд, уйгур үгийн дуудлагыг хадаж өгөх хэрэгтэй болжээ. Энэ хэрэг манж алигали үсэггүйгээр бүтэшгүй юм. Бидний бодлоор барагцаалбал, 18-р зууны эхний хагасын сүүлээр манж алигали үсгийг манжийн гадаад үсэг болон Аюуш гүүшийн галигт тулгуурлан боловсруулсан байна.

Төвд судар шастирын манж орчуулга хийгээд төвд хэлт манж орчуулгын толийн зүйлийг голлон эрхэлж оролцсон хүний нэг нь яах аргагүй II Жанжаа хутагт Ролбийдорж (1717-1786) байсан бололтой.

Үүнд, Дармадалагийн "Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой" зохиолд: "...Эзэн хаанаас өөрийн язгуурын манж аймаг энэ агуу их бөгөөд их олноор шашинд орсон боловч хэл бичиг бусдаар өөр бөгөөд үүнээс урьд манжийн хэлэнд ном орчуулсан ихгүй тул Ганжуурыг манж хэлэнд орчуулбал хойтыг залгамжлагч нарт үлэмж тустай болохыг болгоож Жанжаа гэгээнд "Ганжуур"-ыг манж хэлэнд оруул хэмээн зарлиг буулгасан. Тэгээд сургуулийн сайд нар ба Бээжингийн лам нарын дотроос хэл бичгийн онц мэргэжилтэн сайн эрдэмтэн хэдэн хуушаантай хамтаар "Ганжуур" орчуулж эхэлжээ. Боть нэг нэгийг төгсгөхийн хамт Жанжаа гэгээн ариутгал хийж хаанд болгоосонд хаанаас зарим засвартай нэгнийг засчээ" гэжээ. (219т)

Таван хэлний толь бичгийн III ботийн эцэст Хятадын толь зүйч Хуан Мин Синь "Таван зүйлийн үсгээр хавсарсан толь бичигт холбогдох түүхийн баримтууд" хэмээх өгүүлэл оруулсан бөгөөд түүндээ "Төвд үсгийн гол найруулагч нь Жанжаа хутагтын хоёрдугаар дүр мөн гэж нэлээд хүмүүс итгэж байна. Манж Ганжуур, дөрвөн зүйлийн үсгээр хавсарсан Баатараа явагч нэрт их хөлгөн судар болон Сундуйг хянасан хүн мөн бөгөөд хятад хэлээр ном тавьж чаддаг хүн байжээ. Төвд үсгийг цөмийг энэ хүн эрхлэн найруулсан гэж итгэж болно" гэж бичжээ. Энэ талаархи мэдээ төвд хэлээр буй Жанжаа хутагтын намтар, дээр дурдсан Баатараа явагч нэрт их хөлгөн сударт Тэнгэрийн тэтгэсэн хааны бичсэн оршил, Дүн хуа лү гэдэг зохиол зэрэгт байдаг юм байна.

Хуан Мин Синь-ийн бичсэнээр санскрит авиаг орчуулан хянасан гол хүмүүсийн нэгэн бол Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны зүүн этгээдийн дэд сайдын тушаалд байсан Үлэмж мөн бөгөөд тэр бээр 1771 онд өвчний учир тушаалаас чөлөөлөгдсөн боловч төвд хэлний холбогдолтой ном тарнийн гол явдлын газрыг эрхлэн хамаарч байсан гэжээ. 1766 онд Саган сэцэний "Эрдэнийн товч"-ийг манжаар орчуулахдаа уг эхдээ монголоор байгаа эртний Энэтхэг, Төвдийн хаадын нэрийг цөм самгарди нэрээр нь буулгасан байдгийг үзвэл Үлэмж нь үнэхээр самгарди хэлний өндөр мэдлэгтэй байсан аж. Иймд манж алигали үсгийг боловсруулахад II Жанжаа хутагт, Үлэмж нар тус тус зохих үүрэг гүйцэтгэсэн юм уу, эсвэл ямар нэгэн хэмжээгээр нэр холбогдох ёстой гэж үзэж байна.

4. Манж алигали үсэг

Самгарди үсгийн галиг

Эгшиг үсэг

1. Самгарди бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
2. Төвд бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
3. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
4. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
5. Манж бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
6. Латин галиг	a	a	i	i	u	u	r	r

1. Самгарди бичиг	ᠠᠤ	ᠡᠤ	ᠢᠤ	ᠣᠤ	ᠤᠤ	ᠥᠤ	ᠦᠤ	ᠦᠤ
2. Төвд бичиг	ᠠᠤ	ᠡᠤ	ᠢᠤ	ᠣᠤ	ᠤᠤ	ᠥᠤ	ᠦᠤ	ᠦᠤ
3. Монгол бичиг	ᠠᠤ	ᠡᠤ	ᠢᠤ	ᠣᠤ	ᠤᠤ	ᠥᠤ	ᠦᠤ	ᠦᠤ
4. Тод бичиг	ᠠᠤ	ᠡᠤ	ᠢᠤ	ᠣᠤ	ᠤᠤ	ᠥᠤ	ᠦᠤ	ᠦᠤ
5. Манж бичиг	ᠠᠤ	ᠡᠤ	ᠢᠤ	ᠣᠤ	ᠤᠤ	ᠥᠤ	ᠦᠤ	ᠦᠤ
6. Латин галиг	!	!	e	ai	o	au	aᠭ	aᠭ

Гийгүүлэгч үсэг

1. Самгарди бичиг	क	ख	ग	घ	ङ	च	छ	ज
2. Төвд бичиг	᠎ᠠ	ᠬᠠ	ᠭᠠ	ᠭᠡ	ᠨᠠ	ᠴᠠ	ᠴᠡ	ᠵᠠ
3. Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
4. Тод бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
5. Манж бичиг	ᠠᠠ	ᠡᠡ	ᠢᠢ	ᠣᠣ	ᠤᠤ	ᠥᠥ	ᠦᠦ	ᠦᠦ
6. Латин галиг	ka	kha	ga	gha	ṅa	ca	cha	ja

1. Самгарди бичиг	झ	ञ	ट	ठ	ड	ण	त	थ
2. Төвд бичиг	ᠵᠢ	ᠵᠡ	ᠲᠢ	ᠳᠢ	ᠳᠡ	ᠨᠢ	ᠲᠢ	ᠲᠢ
3. Монгол бичиг	ᠵ	ᠶ	ᠲ	ᠳ	ᠳ	ᠨ	ᠲ	ᠲ
4. Тод бичиг	ᠵ	ᠶ	ᠲ	ᠳ	ᠳ	ᠨ	ᠲ	ᠲ
5. Манж бичиг	ᠵᠢ	ᠵᠡ	ᠲᠢ	ᠳᠢ	ᠳᠡ	ᠨᠢ	ᠲᠢ	ᠲᠢ
6. Латин галиг	jha	ña	ṭa	ṭha	ḍa	ḍha	ṇa	ta

1. Самгарди бичиг	थ	द	ध	न	प	फ	ब	भ
2. Төвд бичиг	ᠲᠢ	ᠳᠡ	ᠳᠢ	ᠨᠢ	ᠯᠠ	ᠯᠡ	ᠪᠠ	ᠪᠡ
3. Монгол бичиг	ᠲ	ᠳ	ᠳ	ᠨ	ᠯ	ᠯ	ᠪ	ᠪ
4. Тод бичиг	ᠲ	ᠳ	ᠳ	ᠨ	ᠯ	ᠯ	ᠪ	ᠪ
5. Манж бичиг	ᠲᠢ	ᠳᠢ	ᠳᠢ	ᠨᠢ	ᠯᠠ	ᠯᠡ	ᠪᠠ	ᠪᠡ
6. Латин галиг	tha	da	dha	na	pa	pha	ba	bha

1. Самгарди бичиг	म	य	र	ल	व	श	ष	स	ह	शः
2. Төвд бичиг	ᠮ	ᠶ	ᠷ	ᠯ	ᠪ	ᠰ	ᠱ	ᠰ	ᠬ	ᠰᠢᠶᠢ
3. Монгол бичиг	ᠮᠠ	ᠶᠠ	ᠷᠠ	ᠯᠠ	ᠪᠠ	ᠰᠢ	ᠱᠢ	ᠰᠢ	ᠬᠢ	ᠰᠢᠶᠢ
4. Тод бичиг	ᠮᠠ	ᠶᠠ	ᠷᠠ	ᠯᠠ	ᠪᠠ	ᠰᠢ	ᠱᠢ	ᠰᠢ	ᠬᠢ	ᠰᠢᠶᠢ
5. Манж бичиг	ᠮᠠ	ᠶᠠ	ᠷᠠ	ᠯᠠ	ᠪᠠ	ᠰᠢ	ᠱᠢ	ᠰᠢ	ᠬᠢ	ᠰᠢᠶᠢ
6. Латин галиг	ma	ya	ra	la	va	ᠴa/ᠰa	ᠱa	sa	ha	kᠱa

Төвд үсгийн галиг

Эгшиг үсэг

1. Төвд үсэг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
2. Монгол галиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
3. Тод галиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
4. Манж галиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ
5. Латин галиг	i	u	e	o

Гийгүүлэгч үсэг

1.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
2.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
3.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
4.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
5.	ka	kha	ga	᠋ᠨa	ᠴa	ᠴha	ja	᠋ᠨa

1.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
2.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ
3.	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠦ

4.								
5.	ta	tha	da	na	pa	pha	ba	ma

1.								
2.								
3.								
4.								
5.	ca	cha	ja	va	za	za	'a	ya

1.								
2.								
3.								
4.								
5.	ra	la	ca/la	sa	ha	a		

Нийлмэл үсгийг галиглах байдлыг жишээлэн үзүүлбэл:

Шанаган а^ᠠ үсгийг угтвар үсэг болсон газар - аар тэмдэглэн дагавар үсэг болон уртыг тэмдэглэсэн газар нь сүүл, цацлага хийлгүйгээр нурууг ялимгүй урт татаж шавж бичдэг

байна.

үсгийн галиг нь хэрэв дунд бичих болбол шилбийг нуруунаас хойш илүү гарган бичнэ . . .

一 曼 長

曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長

曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長

曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長

曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長

曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長
曼長

Манж үсгээр дуудлага тэмдэглэсэн төвд хэлээрх "Арван гурван сан"-гийн судар

Ном зүй

1. Walravens, Harmut. *Buddhist Literature of the Manchus, A Catalogue of the Manchu Holdings in the Raghu Vira Collection at the International Academy of Indian Culture*. New Delhi, 1981.
2. Жалсан. "Огторгуйн маань" ба "Тарни дуудахуйн хураангуй арга", Эрдэнийн харгуй, элбэг бүрэн. Хөх хот, 2002.
3. Захоров И. Грамматика маньчжурского языка. Санктпетербург, 1879.
4. Мандах Ө. Монгол хэлний судлал. Хөх хот, 1980.
5. Надмид Ж. Монгол хэл түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм. УБ, 1967.
6. Ринчен Б. *Хэлээ хайрлан энхрийлж, үгийн боловсролыг эрхэмлэе*, Монгол хэл бичгийн асуудлууд. УБ, 1956.
7. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. I-IV дэвтэр. УБ, 1964-1967.
8. Сэржээ Ж. Гантогтох Г. *Монгол галигийн зарчмыг тогтоосон нэгэн зарлигийн тухай*, Хэл зохиол судлал, Т XIV f-14. УБ, 1980. 79-89 –р тал.
9. Төвшинтөгс Б. *Манж үсгийн тухай*, Төв азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон. УБ, 2002.
10. Nan-i araha manju, mongyo, tangyüd hergen-i qamciha tarni hūlara arya.
11. Хааны бичсэн таван хэлээр хавсарсан манж үгний толь бичиг. Бээжин, 1957.
12. Цагаансар. "Хааны бичсэн манж монгол төвд хэл хавсарсан тарни дуудахуйн арга"-ын доторх хэдэн зурвас дуудах аргын тухай, Эрдмийн харгуй, элбэг бүтээл. Хөх хот, 663-667-д
13. Цагаансар. *Алигали үсгийн судлал*, Өвөр Монголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл. Хөх хот, 1998.4
14. Цэрэнсодном Д. *Монгол Данжуурын төгсгөлийн шүлэг*, Хэл зохиол судлал Т-VIII, f-IV, УБ, 1970.
15. Чулуунбаатар Л. Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл: УБ, 2002.
16. Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ, 2002.
17. śanyan sarangya wesihun mutebuhe debungge nomun toytoho (манжаар гар бичмэл судар) .